



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/197

Номгон

Тунгалаг санхүү хөтөлбөрийн 2021 оны
төлөвлөгөө батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “а”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 23 дугаар тогтоолын 2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөө батлах” тухай 2020 оны 2/8 дугаар тогтоолын 102 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тунгалаг санхүү” хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд 9,000,000 (Есөн сая) төгрөгийг ангилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.


3.Хөтөлбөрийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэст даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

1210491

Аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 19-ний
өдрийн А/197 дугаар захирамжийн хавсралт



**“ТУНГАЛАГ САНХҮҮ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Гүйцэтгэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа /он/	Шаардагдах хөрөнгийн хэмжээ /мян.төг/	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6
1. Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын хэрэгжилтийг сайжруулах					
1.1	“Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах /НБББББ /	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сумдын санхүүгийн алба Төсөвт болон ААН байгууллага	2021	-	Хуулийн хэрэгжилтийг хангана.
1.2	Төсөвт байгууллагуудын анхан шатны бүртгэл хөтлөлт, агуулах, эргэлтийн хөрөнгөд гэнэтийн тооллого шалгалт хийх, зөвлөмж өгөх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сумдын санхүүгийн алба	2021	-	Анхан шатны бүртгэл хөтлөлт сайжирч, агуулахын эмх цэгц, хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангасан байна
1.4	Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил алдаа дүгнэлтийг байгууллага тус бүр дээр хэлэлцүүлж, залруулах арга хэмжээг авах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт аудитын алба	2021	-	Санхүүгийн зөрчил дутагдалгүй ажиллах.
1.5	Жилийн эцсийн санхүүгийн аудитын дүгнэлтээр зөрчилтэй болон хязгаарлалттай дүгнэлт авсан байгууллагын дарга, санхүүгийн ажилтнуудад холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт аудитын алба	2021	-	Буруутай албан тушаалтанд хариуцлага тооцож зөрчлийг арилгах.

1	2	3	4	5	6
1.6	Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн программын ашиглалтын судалгааг хийх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Санхүүгийн программ ашиглалтын судалгаанд үндэслэн програмжуулах
1.7	Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс Программын компаниуд ААНэгж байгууллагууд	2021	-	Стандарт хангалт сайжирсан байна.
1.8	Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, баталгаажуулалтыг 85 хувьд хүргэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба ААНэгж байгууллагууд	2021	-	Бүртгэлээр тавих хяналт сайжран, далд эдийн засаг бууран, орлого нэмэгдэх боломж бүрдэнэ
1.9	Төрийн болон орон нутгийн өмчит бүх байгууллагуудын эзэмшлийн газар болон үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийж, балансад тусгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Өмчийн газар, Төсөвт байгууллагууд	2021	-	Төсөвт байгууллагуудын эзэмшлийн газар, хөрөнгийн дахин үнэлгээ хийж, 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан байна.
2. Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх, орон нутгийн төсвийн орлогын бүрдэлтийг сайжруулах					
2.1	Төсвийн төлөвлөлт, эдийн засгийн ангиллаар хууль, эрх зүйн эмхэтгэл боловсруулж, хэвлүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Төсөв захирагч, нягтлан бодогч нар хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх
2.2	Төсөв, санхүүгийн холбогдолтой төрийн байгууллагын баримт бичиг боловсруулалтыг сайжруулж, хуулийн хэрэгжилтийг хангах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Хууль, журмаар олгогдсон эрхийг хэрэгжүүлэх, эрх зүйн баримт бичгийн үндэслэлийг зөв сонгож хэвшүүлэх
2.3	Төсвийн төлөвлөлтийн мэдээллийн систем /ТТМС/-ийг нэвтрүүлэх	Сангийн яам, Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Төсөвт байгууллагууд програмыг бүрэн ашигладаг болсон байна.

1	2	3	4	5	6
2.4	Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын ажиллагсдын цалин хөлс, тогтмол зардал, тавилга, эд хогшил, зөөлөн эдлэлийн судалгааг авч, шинэчлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Судалгаанд үндэслэн төсвийн төлөвлөлтийг хийх
2.5	Төсөвт байгууллагуудын барилга байгууламжийн ашиглалт, их засварын судалгаа авч, нэгтгэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	2021	-	Судалгаанд үндэслэн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх
2.6	Татвар төлөгчийн бүртгэл тооллогын ажлыг хууль хяналтын болон төрийн захиргааны байгууллагуудтай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулж мэдээллийн бааз суурийн зөрүүг арилгана.	Аймгийн ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс Цагдаагийн газар Улсын бүртгэлийн хэлтэс Авто тээврийн төв	2021	-	АТБӨЯХ-ийн албан татвар, галт зэвсэг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчийг Тооллогод хамруулж, татварын бааз суурийн үнэн зөв, бодит байдлыг хангасан байна
2.7	Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж далд эдийн засгийг бууруулан төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлнэ	Аймгийн ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс	2021	-	Татварын суурийг өргөжүүлж нуугдмал орлогыг ил болгож, татвар төлөгчийн албан татвар, ногдуулалт төлөлтөд тавих хяналтыг сайжруулсан байна
2.8	Иргэдийн татварын талаарх мэдлэг боловсрол дээшлүүлэх, сайн дураар татварын хууль тогтоомжийг сахих, татвараа өөрөө тодорхойлон төлөх хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сурталчилгаа хийх	Аймгийн ЗДТГ, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс	2021	1200.0	Иргэдийн санхүүгийн боловсрол дээшлэнэ.

1	2	3	4	5	6
2.9	Төсөвт байгууллага өөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлэх боломжийг эрэлхийлэх.	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Төсөвт байгууллага өөрийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлж байгууллагын үйл ажиллагааг дэмжих зориулалт бүхий хөрөнгө оруулалт хийх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулах
2.10	Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор батлагдсан татварын хувь хэмжээ өнөөгийн эдийн засгийн өсөлттэй уялдуулан шинэчлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Татварын орлогын хувь хэмжээ нэмэгдэнэ.
2.11	Хуулийн хүрээнд Түүхийн дурсгалт, байгалийн үзэсгэлэнт газрууд болон түгээмэл тархацтай ашигт малтмалуудыг хамгаалалтад авч тухайн сумын ИТХ-аар хэлэлцүүлэн төлбөр хураамжтай ашиглуулах эрх зүйн орчин бүрдүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс Сумдын ЗДТГ	2021	-	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэж түүхэн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудын ашиглалт хамгаалалт сайжирна.
2.12	Төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэхдээ Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалын батлагдсан НӨАТ-ын QR код бүхий төлбөрийн баримтыг үндэслэн төлбөр тооцоог гүйцэтгэж хэвших	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Аж ахуй нэгж, татвар төлөгчийн борлуулалтын орлогыг системд шууд татаж татвар ногдуулалт үнэн бодитой болох, далд эдийн засаг буурна.
3.Төрийн сангийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулж, эрдслийг бууруулах					
3.1	Төрийн сангийн төлбөр тооцоонд ашиглагдаж буй хууль тогтоомжийн жишиг сан бий болгож сумдын санхүүгийн албанд мөрдүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчид	2021	-	Хууль тогтоомжийн хэрэглээг дээшлүүлэх, гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх

1	2	3	4	5	6
3.2	Сумдын санхүүгийн албанд шинээр томилогдсон ажилтны гарын авлага боловсруулж, өдөр тутам ашиглах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчид	2021	500,0	Төрийн сангийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа хууль, эрхзүйн актуудыг нэгтгэж, шинэ ажилтныг тухай ажлын байранд ажиллах мэдлэг, чадварыг нэмэгдүүлнэ.
3.3	Шинээр томилогдсон санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч албан тушаалтныг аймгийн төрийн санд дадлагажуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчид	2021	-	Өдөр тутам хийх ёстой ажлуудаа мэддэг болох, шинэ санаачлага хэрэгжүүлж ажиллах
3.4	"Жишиг санхүүгийн алба" үзүүлэх сургалтыг 4 суманд бүсчлэн зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчид	2021	1600,0	Жишиг санхүүгийн албаны үйл ажиллагааг бусад сумын санхүүгийн албаныханд таниулах, туршлага солилцох, сумдын санхүүгийн албаны үйл ажиллагаа нэг стандарттай болох.
3.5	"Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдлийг бууруулах арга замууд" хэлэлцүүлэг, ярилцлага хийх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчид	2021	-	Тулгамдаж буй асуудлуудыг нэгтгэж, эрсдэл бууруулах арга замыг тодорхойлно.
3.6	Төрийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа маягтуудаар сан үүсгэнэ.	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчид	2021	-	Нягтлан бодогч нарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа маягтуудыг нэгтгэж өгснөөр ажил, гүйлгээ хийгдэхгүй буцах, дахин солих зэрэг хүндрэл гарахгүй болно.

1	2	3	4	5	6
3.7	Төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилтийг сайжруулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчид	2021	-	Бүх шатны хяналт, шалгалтаар илрэх алдаа зөрчил арилсан байна.
3.8	Төрийн сангийн тамга, тэмдэг, архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын санхүүгийн алба, нягтлан бодогчид	2021	-	Сумдын санхүүгийн албад төрийн сангийн тамга тэмдэг, санхүүгийн баримтуудыг хадгалах, архивын хадгалалт хамгаалалтын шаардлагыг хангасан гал усанд автахгүй, лац бүхий төмөр шүүгээтэй болсон байх.
4. Санхүү, бүртгэлийн ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх үүрэг хариуцлагыг өндөржүүлэх, удирдах ажилтан, албан хаагчдад санхүүгийн мэдлэг олгох					
4.1	Төсөвт байгууллагуудын эд хариуцагчдыг сургалтад хамруулж, эд хариуцагчийн эрхтэй болгох	Санхүү, төрийн сангийн хэлтэс, ММНБИ-ийн Баянхонгор аймаг дахь салбар	2021	-	Эд хариуцагчдын мэргэжлийн мэдлэгийн түвшин, ур чадвар сайжирсан байна
4.2	Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Сангийн яам ММНБИ Санхүү, төрийн сангийн хэлтэс, Сумдын санхүүгийн алба	2021	2000,0	Стандарт хангалт сайжирсан байна
4.3	Жижиг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч, эд хариуцагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлж, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах, санхүүгийн тайлан гаргалтаар сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс Татварын хэлтэс Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс Улсын бүртгэлийн хэлтэс	2021	-	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах

1	2	3	4	5	6
4.4	Нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийг таниулж, сурталчлах ажлыг зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Монголын нягтлан бодох бүртгэлийн холбоо	2021	-	Мэргэжлийн ёс зүй, харилцааны соёл дээшилнэ.
4.5	Төсөв захирагч нарт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиар сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн Өмчийн газар	2021	--	
4.6	Санхүү бүртгэлийн ажилтнуудад харилцаа хандлагын сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Монголын нягтлан бодох бүртгэлийн холбоо	2021	500,0	Санхүүгийн алба, бүртгэлийн ажилтнуудын идэвхи санаачлага сайжирна
4.7	Төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагуудтай хамтран бүртгэл санхүүгийн ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинар, үзүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, сургалтын үр өгөөжийг дээшлүүлж, мэргэшсэн нягтлан бодогчдын тоог жил бүр нэмэгдүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Монголын нягтлан бодох бүртгэлийн холбоо Сумдын санхүүгийн алба	2021	-	Удирдах болон санхүү бүртгэлийн ажилтнуудын мэдлэг ур чадвар сайжирсан байна.
4.8	Нягтлан бодогчдын ажлыг иж бүрэн үзүүлэлтээр жилд 2 удаа дүгнэж, ур чадварын нэмэгдлийг олгох	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Ур чадварын нэмэгдлийг эдийн засгийн хөшүүрэг болгон ашигладаг болсон байна.
4.9	Удирдах ажилтан, байгууллагын албан хаагчдад санхүүгийн мэдлэг олгох сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	-	Удирдах ажилтан, албан хаагчдын санхүү, хуулийн мэдлэг сайжирсан байна.
4.10	Санхүүгийн албаны ажилтнуудыг чадавхжуулах сургалт	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	800,0	Санхүүгийн албаны ажилтнуудын мэдлэг ур чадвар дээшилсэн байна.

1	2	3	4	5	6
4.11	Шилэн дансны тухай хуулийн сургалт	Төрийн болон Орон нутгийн өмчит ХК, ХХК-ийн удирдлага, нягтлан бодогч Төсөвт байгууллагуудын төсөв захирагч Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт	2021	600,0	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 95%-д хүргэх.
4.12	Санхүүгийн програмын сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Програмын компаниуд	2021		Санхүүгийн программ ашиглалтыг сайжруулах
4.13	Төсөвт байгууллагын албан хаагчдад хууль эрх зүй, зардлын ангилал тус бүрээр сургалт зохион байгуулах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021		Ажилтнуудын санхүүгийн мэдлэг мэдээлэл дээшлэх
5. Төсвийн ил тод байдлыг хангах					
5.1	Санхүү, бүртгэлийн ажилтан, төсөв захирагч нарын утасны жагсаалт номыг хэвлүүлэх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021	2000,0	Санхүүгийн ажилтнуудыг уялдаа холбоо сайжирна.
5.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021		Шилэн дансны тайлангийн ирцийг 95 хувьд хүргэх
5.3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба	2021		
5.4	Төсвийн төлөвлөлт, эдийн засгийн ангиллаар хууль, эрх зүйн брошур боловсруулан хэвлүүлж, түгээх	Санхүү, төрийн сангийн хэлтэс	2021		Иргэдэд төсөв, санхүүгийн талаарх эрх зүйн мэдлэг олгох
5.5	"Иргэний төсөв-Баянхонгор" төсвийн гүйцэтгэлийн товхимол бэлтгэж, иргэдэд түгээх	Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс	2021	1000,0	Төсвийн гүйцэтгэлийг иргэд, олон нийтэд мэдээлэх

1	2	3	4	5	6
5.6	Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах	Санхүү төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн хяналт аудитын алба, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Статистикийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Төрийн аудит, Монгол банк, арилжааны банкууд	2021		Байгууллагууд үйл ажиллагаагаа сурталчлан танилцуулах, иргэд олон нийтэд төсөв, санхүүгийн мэдээлэл өгөх